



ШУТИС-ийн Бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журам ШУТИС-СҮ-ЖУ	Эхний хөвлөлт	1991.05.01
	Өөрчилсөн огноо	2026.04.07
	Өөрчлөлтийн дугаар	37

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэн суралцахаар хүсэлт гаргагч, оюутан элсүүлэх үйл явцыг удирдан зохион байгуулах элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2. Боловсролын Яамнаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох стандартад нийцүүлэн сургуулийн Удирдах Зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтаан ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлнэ.
- 1.3. Дээд боловсролын тухайн хуулийн 18 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны 115, 2024 оны 103, 2025 оны 215 дугаар тогтоол, Боловсролын сайдын 2024 оны А/66, А/143, А/146, 2025 оны А/69, А/287, 2026 оны А/34 дугаар тушаалыг тус тус мөрдөнө.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Энэхүү журам нь ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2026-2027 оны хичээлийн жилд элсэгчийг бүртгэх, ур чадварын шалгалт зохион байгуулах, оноогоор эрэмбэлэх, хөтөлбөр сонголт хийлгэх, баталгаажуулах, элсүүлэх үйл явцыг тус тус хамарна.

ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. Элсэлтийн шалгалт (цаашид ЭШ гэх) гэж Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэн суралцахад шаардагдах сурах ерөнхий чадвар, мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг;
- 3.2. Монгол хэл бичгийн шалгалт (цаашид МХБШ гэх) гэж эх хэлний боловсролын чанар, хэрэглээ, иргэдийн харилцааны соёл, эх хэлний дархлааны түвшин тогтоох монгол хэл, бичгийн шалгалтыг;
- 3.3. Ур чадварын шалгалт гэж зарим хөтөлбөрийн дагалдах(ЭШ-2) хичээлд тооцох, ШУТИС-аас зохион байгуулах нэмэлт шалгалтыг;
- 3.4. Элсэлтийн комисс гэж элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг; (Комисс нь төв ба дэд, салбар комисс гэсэн хэлбэртэй байна)
- 3.5. Ур чадварын шалгалтын комисс гэж ур чадварын шалгалтыг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;
- 3.6. Хяналтын тоо гэж сургуулийн Удирдах зөвлөлөөс баталсан хөтөлбөрт элсүүлэх оюутны тоог;
- 3.7. Элсэлтийн систем гэж элсэлтийн цахим бүртгэлийн системийг;
- 3.8. Элсэлтийн бүртгэл гэж элсэлтийн веб хуудсаар дамжуулан элсэлтийн системд нэвтэрч, хувийн мэдээллийг оруулан, элсэх хүсэлтэй хэд хэдэн хөтөлбөрийг сонгож, цахимаар төлбөр төлж баталгаажуулах үйл явцыг;
- 3.9. Бүртгүүлэгч гэж ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэх хүсэлт гаргасан иргэнийг;



- 3.10. Эрэмбэ гэж суурь ба дагалдах(зарим хөтөлбөрт ур чадварын шалгалт) хичээлийн онооноос бүртгүүлэгчдийн нийлбэр оноог тооцоолж, сонгож бүртгүүлсэн хөтөлбөр бүрээр босго оноотой нь харьцуулан жагсаалт үүсгэхийг;
- 3.11. Хөтөлбөр сонголт, баталгаажуулалт гэж ШУТИС-ийн тухайн сургалтын хөтөлбөрт тохирох хичээлүүдээр ЭШ өгсөн бүртгүүлэгч босго онооны болзол ханган, онооны жагсаалтын дагуу хөтөлбөр сонгон, баталгаажуулах үйл явцыг;
- 3.12. 1 кредитийн төлбөр гэж тухайн хичээлийн жилд мөрдөхөөр удирдах зөвлөлөөс тогтоосон, хичээлийн нэгж кредитэд ноогдох төлбөрийг;
- 3.13. Элсэгч гэж хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг;
- 3.14. Гадаадын иргэн гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй буюу гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг;
- 3.15. Зэргийн бус сургалт гэж дурын иргэнд тодорхой чиглэлээр мэдлэг, боловсролоо дээшлүүлэх боломж олгох, боловсролын зэрэг олгохгүй сургалтыг;
- 3.16. “Т” гэж тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрийг;
- 3.17. “Э” гэж эрэлттэй чиглэлийн хөтөлбөрийг;
- 3.18. Журамд дурдсан ШУТИС-ийн бүрэлдэхүүн, харьяа сургуулийн товчилсон нэрийг хүснэгт 1-д үзүүлснээр хэрэглэнэ.

Хүснэгт 1.

д/д	Сургуулийн нэр	Товчлол
1	Барилга, архитектурын сургууль	БАС
2	Гадаад хэлний сургууль	ГХС
3	Геологи, уул уурхайн сургууль	ГУУС
4	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	ДаТС
5	Механик инженер, тээврийн сургууль	МИТС
6	Менежментийн сургууль	МС
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	МХТС
8	Нийгэм, хүмүүнлэгийн сургууль	НХС
9	Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайн сургууль	ХХУДС
10	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	ХШУС
11	Эрчим хүчний инженерчлэлийн сургууль	ЭХИС
12	“Эрдэнэт цогцолбор” дээд сургууль	ЭЦДС
13	Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль	ӨМТДС

ДӨРӨВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

4.1. ШУТИС-ийн Ректор

- 4.1.1 Элсэлтийн төв ба дэд комиссыг тушаалаар батална.
- 4.1.2 Ур чадварын шалгалтын комисс, шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүнийг тушаалаар батална.
- 4.1.3 Элсэлтийн үйл ажиллагааны явцтай танилцаж санал, зөвлөмж өгнө.



- 4.1.4 Элсэлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлангаар танилцаж үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 4.2. **Элсэлтийн төв комисс**
- 4.2.1 Элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар ханган, ажлын төлөвлөгөө, төсвийг баталж, хэрэгжүүлнэ.
- 4.2.2 Элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.
- 4.2.3 Ур чадварын шалгалт зохион байгуулах комиссыг байгуулж ажиллуулна.
- 4.2.4 Элсэлтийн маркетингийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 4.2.5 Элсэлтийн үеийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.
- 4.2.6 Тухайн журмаар зохицуулагдаагүй асуудлыг бүрэлдэхүүн/харьяа сургуулийн саналыг үндэслэн комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.
- 4.3. **Элсэлтийн дэд комисс**
- 4.3.1 Элсэлтийн маркетингийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв гаргаж, батлуулан хэрэгжүүлнэ.
- 4.3.2 Элсэлттэй холбоотой боловсролын үзэсгэлэнд оролцох, хөтөлбөрүүдийг нийтэд танилцуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр сурталчлах, элсэлтийн сурталчилгааны материал бэлтгэх ажлыг зохион байгуулна.
- 4.3.3 Элсэлтийн маркетингийн үйл ажиллагааг тайлагнана.
- 4.4. **Элсэлтийн салбар комисс**
- 4.4.1 ШУТИС-ийн ДаТС, ШУТИС-ийн харьяа ЭЦДС, ӨмТДС-д элсэлтийн салбар комисс байгуулж 5.2, 5.3-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 4.5. **Сургалтын бодлого, зохицуулалтын алба**
- 4.5.1 Элсэлтийн журам боловсруулж, батлуулна.
- 4.5.2 Элсэлтийн төв комисс, дэд комисс, ур чадварын шалгалтын комиссын бүрэлдэхүүний тушаалыг батлуулна.
- 4.5.3 Элсэлтийн дэд, салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран ажиллана.
- 4.5.4 Элсэлттэй холбоотой үндсэн үйл ажиллагааг зохицуулах, шаардлагатай бичиг баримтууд боловсруулах, оролцогч талуудыг мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.
- 4.5.5 Элсэлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайланг бэлтгэж, ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 4.6. **Мэдээллийн технологийн төв**
- 4.6.1 Цахим элсэлтийн бүртгэл, хуваарь сонголтын программ хангамжийг шинэчлэн хөгжүүлнэ.
- 4.6.2 Бүртгүүлэгчдийг мэдээллээр хангах гар утасны аппликейшн программд бэлтгэсэн мэдээллийг оруулах, шинэчлэх ажлыг хариуцна.
- 4.6.3 Элсэлтийн веб сайтад холбогдох мэдээллийг оруулах, шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ.
- 4.6.4 Цахим элсэлтийн программ хангамжийн найдвартай, хэвийн ажиллагааг хангана.
- 4.6.5 Сервер, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангана.
- 4.7. **Эрүүл мэндийн төв**



- 4.7.1 Шинээр элсэгчдэд эрүүл мэндийн даатгал, түүнийг ач холбогдол, хэрхэн хамрагдах талаар танилцуулга, мэдээлэл хүргэнэ.
- 4.7.2 Шинээр элсэгчдийн эрүүл мэндийн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулна.
- 4.7.3 Ур чадварын шалгалт зохион байгуулагдах үед эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 4.8. **Бүрэлдэхүүн, харьяа сургууль**
- 4.8.1 Хөтөлбөр хариуцаж байгаа тэнхимүүд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдэд элсэгчийн тоог нэмэгдүүлэх зорилгоор тусгайлан ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ба энэ үйл ажиллагаанд багшлах бүрэлдэхүүнийг татан оролцуулна.
- 4.8.2 Сургалтын хөтөлбөрийн талаарх цахим болон хэвлэмэл танилцуулга материал боловсруулж түгээх, мөн бусад хэлбэрээр хөтөлбөрөө сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 4.8.3 Шинэ элсэгчтэй суралцах гэрээг цахимаар байгуулан зөвлөх багш, сургалтын албаар дамжуулан сургалтын үйл ажиллагааг танилцуулж, хичээл сонголтыг зохион байгуулна.
- 4.8.4 Шинэ элсэгч, зөвлөх багш нартай уулзалт, өдөрлөг, чиглүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 4.9. **Бүртгүүлэгч, Элсэгч**
- 4.9.1 ШУТИС-ийн элсэлтийн журам, элсэгчдэд зориулсан веб хуудас, бусад материалтай танилцаж элсэлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар мэдээлэл авна.
- 4.9.2 Элсэлтийн бүртгэлийн системд хувийн мэдээллээ үнэн зөв оруулж, өөрийн сонирхсон хөтөлбөрүүдээс сонгон бүртгүүлнэ.
- 4.9.3 Босго онооны болзол хангасан бүртгүүлэгч цахим элсэлтийн системээр дамжуулан хөтөлбөр сонголт хийж, заасан хугацаанд баталгаажуулна.
- 4.9.4 Хөтөлбөр баталгаажуулалт хийсэн элсэгч сонгосон хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бүрэлдэхүүн, харьяа сургуультай суралцах гэрээг цахимаар байгуулна.

ТАВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

- 5.1. 2026-2027 оны хичээлийн жилийн элсэлтийн бүртгэлийг элсэлтийн төв комиссоос гаргасан хуваарийн дагуу улс орон даяар цахим хэлбэрээр зохион байгуулна. Бүртгэлийн хуваарийг элсэлтийн вебээр (www.elselt.edu.mn) дамжуулан нийтэд түгээнэ.
- 5.2. ЭШ өгсөн, тухайн онд ЭШ өгөхөөр бүртгүүлсэн, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноогоо дүйцүүлэн тооцуулж батламж авсан бүртгүүлэгч нь элсэлтийн веб (www.elselt.edu.mn) хуудсаар элсэлтийн системд БҮТ-д бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан бүртгүүлнэ. Бүртгүүлэгч ЭШ-ыг хэд хэдэн удаа өгсөн бол сүүлийн ЭШ-ын бүртгэлийн дугаараар бүртгэлд хамрагдана.
- 5.3. Өмнө нь ЭШ, МХБШ өгсөн бол батламж нь шалгалт өгсөн өдрөөс хойш 2 жил 8 сарын хугацаанд хүчинтэй байх нөхцөлийг хангасан байна.
- 5.4. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд шаардлагатай хувийн мэдээллийг оруулан, ШУТИС-ийн бүрэлдэхүүн БАС, ГХС, ГУУС, ДаТС, МИТС, МС, МХТС, НХС, ХХҮДС, ХШУС, ЭХИС, ШУТИС-ийн харьяа ЭЦДС, ӨмТДС-ийн хэрэгжүүлж байгаа үндсэн болон гадаад, дотоодын хамтарсан, Англи хэлээр хэрэгжүүлэх хөтөлбөрөөс өөрийн



сонирхлын дагуу урьдчилсан байдлаар 8 хүртэл хөтөлбөрийг сонгон бүртгүүлэх ба элсэлтийн бүртгэл хаах хугацаанаас өмнө сонгосон хөтөлбөрийн жагсаалтыг 2 удаа өөрчилж болно.

- 5.5. Бүртгүүлэгч нь ШУТИС-ийн элсэлтийн журамтай танилцаж, шаардлагуудыг хүлээн зөвшөөрсөн эсэхээ заавал баталгаажуулах ба бүртгэлийн хураамжийг цахимаар төлж баталгаажуулснаар бүртгэл хүчин төгөлдөр болно.
- 5.6. Элсэлтийн бүртгэлийн хураамжийг ШУТИС-ийн элсэлтийн төв комисс баталж, тухайн хичээлийн жилд мөрдөх ба буцаан олголт хийхгүй.
- 5.7. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг өөрөө хариуцах ба алдаатай, буруу мэдээлэл оруулснаас үүсэх хариуцлагыг ШУТИС хүлээхгүй.
- 5.8. Хавсралт 1-д заасан бакалаврын үндсэн хөтөлбөрүүдийг тухайн бүрэлдэхүүн, харьяа сургууль хариуцан хэрэгжүүлэх ба элсэгч энд заасан сургалтын хугацаанд, харгалзах кредитийг цуглуулж төгсөх болзол хангана.
- 5.9. Хавсралт 2-д заасан гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрийн эхний 2 эсвэл 3 жилийн сургалтыг тухайн бүрэлдэхүүн сургууль, сүүлийн жилүүдийн сургалтыг тухайн улсын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нэгж тус тус хариуцах ба төгсөх болзол хангасан суралцагчид 2 сургуулийн бакалаврын зэрэг, диплом олгоно.
- 5.10. Хавсралт 2-д заасан дотоодын их, дээд сургуультай хамтарсан хөтөлбөрийн эхний 1 эсвэл 2 жилийн сургалтыг тухайн орон нутагт байрлах сургууль, сүүлийн жилүүдийн сургалтыг Улаанбаатар хотод байрлах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бүрэлдэхүүн сургууль тус тус хариуцах ба төгсөх болзол хангасан суралцагчид Улаанбаатар хотын бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын зэрэг, диплом олгоно.
- 5.11. Хавсралт 3-д заасан Англи хэл дээр хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрт элсэх бүртгүүлэгч нь тухайн хөтөлбөрийн элсэлтийн шалгалтын босго онооны шаардлага хангасан байхаас гадна Англи хэлний олон улсын стандарт шалгалтын (Европын олон хэлний стандарт (CEFR)-ын B1 түвшин, IELTS 5.5, TOEFL IBT 60, TOEIC 650, Duolingo 75 ба түүнээс дээш) онооны шаардлагыг хангасан байна.
- 5.12. ХШУС-ийн хэрэгжүүлж байгаа Герман хэлээр сургалт нь явагдах “Статистик” хөтөлбөрт эхний 2 жилийн сургалтаар Герман хэлийг гүнзгийрүүлэн судлахаас гадна 1, 2-р курсийн цөм суурь хичээлүүд Герман хэлээр заагдана. Хөтөлбөрийн суралцагч 1 эсвэл 2-р курс төгссөний дараа Герман улсын их, дээд сургуульд хувиараа элсэн суралцах хүсэлт гаргах эсвэл “Статистик”-ийн үндсэн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцаж болно.
- 5.13. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, Политехник коллежийг мэргэжлийн боловсролын үнэмлэхтэй төгссөн төгсөгч нь ЭШ өгч, бакалаврын хөтөлбөрт тавигдах босго онооны болзол хангасан тохиолдолд сонирхсон хөтөлбөрөөр элсэн суралцаж болно.
- 5.14. ШУТИС-ийн оюутан дахин ЭШ өгч, өөр хөтөлбөрөөр элсэх тохиолдолд өмнө судалсан хичээлийг дүйцүүлэх эсэх асуудлыг сургалтын журмаар зохицуулна.
- 5.15. ШУТИС-д бакалаврын хөтөлбөрт суралцахаар хүсэлт гаргасан гадаадын иргэнийг Монгол хэлний мэдлэг, чадварын шалгалт, эсвэл Англи хэлний олон улсын шалгалтын оноог харгалзан элсүүлэх ба бусад асуудлыг тусдаа журмаар зохицуулна.



ЗУРГАА. УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ

- 6.1. Элсэлтийн www.elselt.edu.mn веб хуудсаар элсэлтийн системд ур чадварын шалгалт тооцох хөтөлбөрийг сонгон бүртгүүлж, бүртгэлийн хураамж төлсөн бүртгүүлэгчдийг ур чадварын шалгалтад хамруулна.
- 6.2. Ур чадварын шалгалт тооцох хөтөлбөрт Архитектур, Анимейшн, мультимедиа дизайн, Хувцасны дизайн, Үйлдвэрлэлийн дизайн, Интерьер дизайн, График дизайн, Аялал жуулчлал хөтөлбөр багтана.
- 6.3. Ур чадварын шалгалтыг тусгай удирдамжийн дагуу комисс зохион байгуулна. Удирдамжид шалгалтын агуулга, хэлбэр, бүтэц, хугацаа, дүгнэх аргачлалыг тусгаж, элсэлтийн веб хуудсанд нээлттэй байршуулна.
- 6.4. ШУТИС-ийн оюутан ур чадварын шалгалт тооцох хөтөлбөрт шилжин суралцах бол тухайн шалгалтад хамрагдаж болно.
- 6.5. Ур чадварын шалгалтыг 0-100 оноогоор дүгнэх ба тус оноог хүснэгт 2-д үзүүлсэн аргачлалаар хэмжээст оноонд шилжүүлнэ. Шалгалтын оноог гүйцэтгэлийн хувиар давхар гаргасан байна.
- 6.6. Ур чадварын шалгалтын оноог элсэлтийн системд оруулсны дараа шалгуулагч өөрийн бүртгэлээр нэвтэрч оноогоо харна. Ур чадварын шалгалт нь тухайн жилдээ (хавар, өвөл) хүчинтэй байна.
- 6.7. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон “Техник технологийн улсын олимпиад”-ын Дизайн технологи, зураг зүй; Дүрслэх урлагийн төрлүүдэд эхний 5 байрт шалгарсан бүртгүүлэгчийн ур чадварын шалгалтын оноог шууд тооцно. Ур чадварын оноог дүйцүүлэн тооцох нэмэлт шаардлага, мэдээллийг элсэлтийн комисс тодорхойлж, элсэлтийн веб сайтаар нийтэд түгээнэ.

Хүснэгт 2. Шалгалтын оноог хэмжээст оноонд шилжүүлэх аргачлал

№	Шалгалтын оноо	Хэмжээст оноо
1	95-100	760-800
2	90-94.9	720-759
3	85-89.9	680-719
4	80-84.9	640-679
5	75-79.9	600-639
6	70-74.9	560-599
7	65-69.9	520-559
8	60-64.9	480-519
9	0-59	200-479

ДОЛОО. ОНООНЫ ЖАГСААЛТ, ЭРЭМБЭ

- 7.1. Элсэлтийн бүртгэл хаагдсаны дараа бүртгэлээ баталгаажуулсан бүртгүүлэгчдийн ЭШ-ын онооны мэдээллийг БҮТ-ийн серверээс блокчейн сүлжээгээр дамжуулан ШУТИС-ийн элсэлтийн системд татаж, суурь ба дагалдах(зарим хөтөлбөрт ур чадварын шалгалт) хичээлийн онооноос нийлбэр оноог тооцоолж, сонгож бүртгүүлсэн хөтөлбөр бүрээр босго оноотой харьцуулан жагсаалт, эрэмбэ үүсгэнэ.
- 7.2. Суурь шалгалтад тооцох 2 хичээлийн (зарим хөтөлбөрт 1 хичээл) хамгийн өндөр оноотой хичээлийн оноог нийлбэр онооны 70%, дагалдах хичээлийн шалгалтад



тооцох 2 хичээлийн (зарим хөтөлбөрт 1 хичээл) хамгийн өндөр оноотой хичээлийн оноог нийлбэр онооны 30%-д тус тус тооцож нийлбэр оноог гаргана.

- 7.3. Эрэмбэлэх үед бүртгүүлэгчийн нийлбэр оноо нь тэнцвэл ЭШ-ын гүйцэтгэлийн хувийг харгалзана. ЭШ-ын гүйцэтгэлийн хувийг 7.2 заалтын дагуу тооцно.
- 7.4. ШУТИС-д элсэлт авах үндсэн хөтөлбөрүүдэд харгалзах босго оноог хавсралт 1, гадаад, дотоодын их дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрүүдэд харгалзах босго оноог хавсралт 2, Англи хэлээр хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд харгалзах босго оноог хавсралт 3-д заасны дагуу тооцно. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй харьяа сургуулиудын хувьд Боловсролын яамнаас баталсан босго оноог (430) баримтална.
- 7.5. Олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноогоо дүйцүүлэн тооцуулж батламж авсан бүртгүүлэгчийн дүйцүүлсэн оноог үндэслэн ЭШ өгсөн бүртгүүлэгчдийн хамт жагсааж эрэмбэлнэ.
- 7.6. 2026 онд Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Орхон аймаг дахь ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийг төгссөн, ЭШ-ын оноо нь ШУТИС-ийн босго онооны болзол хангасан төгсөгчдийг тухайн ахлах сургууль дотор нь оноогоор жагсааж, хуваарилсан хяналтын тоонд багтаан хөтөлбөр сонгуулж, шууд элсүүлэн суралцуулна.
- 7.7. ШУТИС-ийн харьяа Технологийн коллежууд(коосэн), ШУТИС-ийн харьяа Политехник коллеж, ШУТИС-ийн харьяа Хөвсгөл, Өмнөговь, Орхон аймаг дахь Политехник коллежийг техникийн боловсролын дипломтой төгссөн бүртгүүлэгчийг төгссөн мэргэжлийн салбар чиглэлээр бакалаврын хөтөлбөрт шууд элсүүлнэ. Судалсан хичээлийг дүйцүүлэх асуудлыг “Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-д зааснаар шийдвэрлэнэ.
- 7.8. ШУТИС-д элсэн суралцах сонирхолтой авьяаслаг элсэгчийг дэмжих зорилгоор сүүлийн 2 жилийн хугацаанд оюун ухаан, урлагийн төрлөөр олон улсын тэмцээн, спортын төрлөөр олимп, дэлхийн болон тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт болон шагналт байр эзэлсэн эсвэл улсын чанартай тэмцээнд медальт байрт шалгарсан бүртгүүлэгчдийг элсэлтийн шалгалтын босго онооны шаардлага хангасан тохиолдолд сургуулийн саналыг үндэслэн элсэлтийн комиссын шийдвэрээр сонирхсон хөтөлбөрт нь шууд элсүүлнэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨР СОНГОЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ

- 8.1. Хөтөлбөр сонголтын үйл ажиллагааг www.elselt.edu.mn элсэлтийн веб хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр явуулна.
- 8.2. Хөтөлбөр сонгох зарчим, үйл ажиллагааны дараалал болон хөтөлбөр сонголт эхлэх, дуусах өдрийг элсэлтийн төв комисс тодорхойлж, мэдээллийг элсэлтийн веб хуудсаар дамжуулан нийтэд урьдчилан хүргэнэ.
- 8.3. Бүртгүүлэгч системд нэвтрэн, сонгож бүртгүүлсэн хөтөлбөр бүрээр хяналтын тоонд багтсан эсэхээ урьдчилан шалгана. Бүртгүүлэгч сонгож бүртгүүлсэн хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан бол тухайн хөтөлбөрийг дараалал харгалзахгүй сонгох эрхтэй болно.
- 8.4. Бүртгүүлэгч сонгож бүртгүүлсэн хөтөлбөрийн хяналтын тоонд багтаагүй бол өөрийн өмнө эрэмбэлэгдсэн бүртгүүлэгчдийн хөтөлбөр сонголтын үр дүнг харгалзан эрэмбэ дээшилж хяналтын тоонд багтах боломжийг хүлээнэ.



- 8.5. Хөтөлбөр сонгох үйл ажиллагаа хуваарьт өдрүүдэд 08.00-22.00 цагийн хооронд үргэлжлэх ба бүртгүүлэгч өөрийн сонгосон хөтөлбөрүүдээс хяналтын тоонд багтсан аль нэг хөтөлбөрийг 1 цагийн дотор сонгож, 2 цагийн дотор 1 кредитийн төлбөр төлж баталгаажуулалт хийнэ.
- 8.6. Бүртгүүлэгч 1 цагийн дотор хөтөлбөрөө сонгосон боловч 2 цагтаа багтаж 1 кредитийн төлбөрөө төлж баталгаажуулалт хийгээгүй тохиолдолд дахин 1 удаа жагсаалтад оруулж тухайн хөтөлбөрийг дахин сонгох боломж олгоно. Харин ямар нэгэн сонголт хийгээгүй бол тухайн хөтөлбөрийг сонгохоос татгалзсан гэж үзэж жагсаалтаас хасна.
- 8.7. Бүртгүүлэгч баталгаажуулах хугацааг дуусгахгүйгээр сонгосон хөтөлбөрийг өөрийн саналаар цуцалж өөр хөтөлбөр сонгож болно.
- 8.8. Бүртгүүлэгч анх сонгон бүртгүүлсэн хөтөлбөрөөс гадна бүртгүүлэгчийн тоо нь хяналтын тооноос бага байгаа бусад хөтөлбөрөөс шууд сонголт хийж болно.
- 8.9. Хөтөлбөр сонголтыг хуваарьт өдрүүдэд хэд хэдэн давталтаар гүйцэтгэсний дараа элсэлтийн хяналтын тоо гүйцээгүй хөтөлбөрийг нээлттэй хэлбэрээр зарлан хөтөлбөр сонголтыг үргэлжлүүлнэ.
- 8.10. Нээлттэй хэлбэрээр хөтөлбөр сонголтын үйл ажиллагааг цахим системээр тасралтгүй явуулахаас гадна Элсэлтийн комисс, бүрэлдэхүүн сургуулиуд дээр элсэлтийн асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг тухай бүр нь шийдвэрлэж ажиллана.
- 8.11. Хөтөлбөр баталгаажуулалт хийсэн тохиолдолд “ШУТИС-д суралцах эрхийн бичиг” цахимаар олгогдох ба элсэгч зарласан хугацаанд анкет бөглөн оюутны код авч дараагийн үйл ажиллагаанд шилжинэ.
- 8.12. Хөтөлбөр сонголтыг баталгаажуулсан 1 кредитийн төлбөрийг элсэгчийн сургалтын төлбөрт тооцно. Элсэгч баталгаажуулсан хөтөлбөрөө цуцлах, эсвэл сургалтын явцад суралцахаас татгалзсан тохиолдолд дараагийн бүртгүүлэгчийн хөтөлбөр сонгох боломжийг хаасан үндэслэлээр хөтөлбөр баталгаажуулалтын 1 кредитийн төлбөрийг буцаан олгохгүй.
- 8.13. Олон улсын болон Боловсролын яамнаас баталсан улсын олимпиадуудад амжилттай оролцож эхний 5 байр эзэлсэн бүртгүүлэгчид тухайн хөтөлбөрийн босго онооны болзол хангасан тохиолдолд давуу эрхтэйгээр хөтөлбөр сонголт хийлгэхээс гадна эхний жилд сургалтын төлбөрийн тодорхой хувийн хөнгөлөлт үзүүлнэ.
- 8.14. ШУТИС-ийн хэрэгжүүлж байгаа зарим хөтөлбөрөөр тухайн орон нутагт ажлын байрны эрэлт хэрэгцээ үүсэж, оюутан элсүүлэх албан захиалга ирсэн тохиолдолд босго онооны болзол хангасан бүртгүүлэгчийг ШУТИС-д элсүүлэн суралцуулах эсэх асуудлыг элсэлтийн төв комисс шийдвэрлэнэ.

ЕС. ЭЛСЭГЧИЙН БҮРТГЭЛ

- 9.1. Суралцах эрхийн бичиг цахимаар авсан элсэгчид зарласан хугацаанд www.elselt.edu.mn элсэлтийн веб хуудсаар элсэлтийн системд нэвтэрч элсэгчийн анкет бөглөн оюутны код, нууц үг авна.
- 9.2. Оюутны код, нууц үгээ ашиглан <https://student.must.edu.mn/> хаягаар оюутны вебд нэвтэрч, суралцах гэрээг цахимаар заавал байгуулж, зөвлөх багшийн мэдээлэл, хичээл сонголт хийх заавар, зөвлөмжтэй танилцах ба бусад шаардлагатай мэдээллийг оюутны гарын авлагаас авна.
- 9.3. Оюутан сургалтын явцдаа Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2-т заасны дагуу Монгол улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ



хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулах үүргийг хэрэгжүүлэх ба ШУТИС-ийн эрүүл мэндийн төвөөс гаргасан удирдамж, хуваарийн дагуу эрт илрүүлэг эсвэл урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдана.

- 9.4. Журмын 10.1-д заасан хугацаанд бүртгүүлж, суралцах гэрээ байгуулаагүй элсэгчдийг ШУТИС-д суралцахаас татгалзсан гэж үзэж элсэх эрхийг нь хүчингүйд тооцно.

АРАВ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ

- 10.1. 2026-2027 оны хичээлийн жилийн элсэгчдийн дунд “ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг” олгох сонгон шалгаруулалт явуулж, шаардлага хангасан элсэгчдэд хичээлийн жилийн турш сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан тохиолдолд 1 удаа 30 хүртэл багц цагийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.
- 10.2. ШУТИС-ийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн чиглэлээр олон улсын болон Боловсролын яамнаас баталсан улсын олимпиадуудад 1-5 байр эзэлсэн элсэгчдэд эхний хичээлийн жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн (50-100) хүртэлх хувийн тэтгэлэг олгоно. Тэтгэлэгт тооцох олимпиадын мэдээллийг элсэлтийн комисс тодорхойлно.
- 10.3. Элсэгч суурь болон дагалдах хичээлд тооцуулсан хичээл тус бүрд 700-750 оноо авсан бол 30 багц цагийн сургалтын төлбөрийн 50%, 751-775 оноо авсан бол 30 багц цагийн сургалтын төлбөрийн 75%, 776-800 оноо авсан бол 30 багц цагийн сургалтын төлбөрийн 100%-ийн тэтгэлэг тус тус олгоно.
- 10.4. Улаанбаатар хот, Дархан-уул аймаг, Орхон аймаг дахь ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль төгссөн элсэгч суурь болон дагалдах хичээлд тооцуулсан хичээл тус бүрд 650-699 оноо авсан бол 30 багц цагийн сургалтын төлбөрийн 50%, 700-749 оноо авсан бол 30 багц цагийн сургалтын төлбөрийн 75%, 750 ба түүнээс дээш оноо авсан бол 30 багц цагийн сургалтын төлбөрийн 100%-ийн тэтгэлэг олгоно.
- 10.5. 10.1 ба 10.2 заалтын дагуу тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргасан элсэгчдийн өргөдөл, материалыг комисс хянаж, шаардлага хангасан элсэгчдэд журамд заасан хувь хэмжээгээр тэтгэлэг олгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 10.6. Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам" -ын дагуу элсэгчдэд зээл, буцалтгүй тусламж, хөнгөлөлт, тэтгэлгийг Боловсролын зээлийн сангаар дамжуулан төрөөс олгоно. Үүнд:
- 10.6.1. Магадлан итгэмжлэгдсэн, тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр элсэн (бакалаврын үндсэн хөтөлбөрт шинээр элсэгч нь элсэлтийн шалгалтад 600 ба түүнээс дээш оноо авсан байх) суралцагчид Засгийн газрын тэтгэлэг олгоно.
- 10.6.2. Нийгмийн салбарт хомсдолтой байгаа зарим мэргэжлийн чиглэлээр (нийгмийн ажилтан, хоол зүй, шим судлалын бакалаврын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр) анхлан элсэн суралцагч элсэлтийн шалгалтад 501-ээс дээш оноо авсан тохиолдолд 100 хувийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.
- 10.6.3. Зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй элсэн суралцагчид сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, хэрэв орон нутгийн харьяалалтай бол дотуур байрны зардал олгоно.



- 10.6.4. Магадлан итгэмжлэгдсэн, үндсэн хөтөлбөрөөр элссэн зорилтот бүлгийн суралцагчид дараах нөхцөлүүдээр сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгоно. Үүнд:
- Бүтэн өнчин;
 - Нэг гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн хагас өнчин элсэгч;
 - Эцэг эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй;
 - Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан өрхийн гишүүнтэй;
 - Цаатан, тува, урианхай үндэстний өрхийн нэг суралцагч.
- 10.6.5. Нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд бакалаврын үндсэн хөтөлбөрөөр зэрэг суралцаж байгаа бол нэг суралцагчид сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгоно.
- 10.6.6. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа, байгууллагын магадлан итгэмжлэл хийгдсэн их сургуулийн “нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн” суралцагчид сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт үзүүлнэ.
- 10.6.7. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр анхлан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл олгоно.
- 10.7. Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6 заалт, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 103 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу сургалтын төлбөрийн дэмжлэгийг Боловсролын зээлийн сангаар дамжуулан төрөөс олгоно.
- 10.8. “072407 индекс бүхий Газрын тосны боловсруулах үйлдвэрийн инженерчлэл” хөтөлбөрөөр элсэгчийн сургалтын төлбөрийг Ашигт малтмал, газрын тосны газраас санхүүжүүлнэ.
- 10.9. “071104 индекс бүхий Нүүрсний боловсруулалтын технологи” бакалаврын хамтарсан (2+2) хөтөлбөрөөр элсэгчид Монгол Улсад суралцах 2 жилийн хугацааны сургалтын төлбөр, дотуур байрны төлбөрийг “Эрдэнэс УТП ХХК”-аас бүрэн санхүүжүүлнэ.
- 10.10. Элсэгч суралцах хугацаандаа гаргасан сурлагын амжилтаасаа хамаарч дараах байгууллага, сангийн тэтгэлгүүдэд хамрагдаж болно. Үүнд:
- 10.10.1 “Сүмитомо” корпорацийн нэрэмжит тэтгэлэг (жил бүрийн 3-4 сар)
 - 10.10.2 “Сасакава”-н тэтгэлэг (жил бүрийн 8-9 сар)
 - 10.10.3 “ШУТИС-Тоёота” сангийн тэтгэлэг (жил бүр)
 - 10.10.4 Газрын тосны хэрэг эрхлэх газар (жил бүр)
 - 10.10.5 Оюу толгой ХХК-ийн тэтгэлэг (жил бүрийн 10 сар)
 - 10.10.6 Эрдэнэс таван толгой ХХК-ийн тэтгэлэг (жил бүр)
 - 10.10.7 Говь ХХК-ийн тэтгэлэг (жил бүр)
 - 10.10.8 Голомт банкны тэтгэлэг (жил бүр)
 - 10.10.9 Хаан банкны тэтгэлэг (жил бүр)
 - 10.10.10 “Санко Сэйки” группийн тэтгэлэг (жил бүрийн 8-9 сар)
 - 10.10.11 Петростар ХХК-ийн тэтгэлэг (жил бүр)
 - 10.10.12 Дашваанжил ХХК-ийн тэтгэлэг (жил бүр)
 - 10.10.13 Бусад тэтгэлгүүд
- 10.11. Сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшууллыг давхардуулж олгохгүй.



АРВАН НЭГ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ШААРДАХГҮЙ, БУСАД ХЭЛБЭРИЙН ЭЛСЭЛТ

11.1. Бакалаврын сургалтын хөтөлбөрт суралцах хүсэлтэй, дараах шалгууруудын аль нэгийг хангасан бүртгүүлэгчээс ЭШ-ийн оноо шаардахгүй элсүүлэн суралцуулна.

Үүнд :

11.1.1 Дотоод, гадаадын аль нэг их, дээд сургуульд дэд бакалавр, бакалаврын боловсрол эзэмшсэн иргэн;

11.1.2 ШУТИС-д элсэлт авах бакалаврын хөтөлбөрийн чиглэлээр политехник коллежийг техникийн боловсролын дипломтой төгссөн, гадаадын аль нэг улсын техникийн коллежийн төгсөгч, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч;

11.1.3 ШУТИС-д элсэн суралцах бакалаврын хөтөлбөрийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн;

11.1.4 Гадаадын аль нэг улсын их, дээд сургуульд суралцаж байгаад ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт шилжин суралцах иргэн;

11.2. Анги танхимын багтаамж, профессор, багшийн ачаалал, нийгмийн эрэлт хэрэгцээ, байгууллагын захиалгыг үндэслэн хүснэгт 3-т заасан сургалтын аль нэг хэлбэрээр элсэлт авах хөтөлбөрийг нээлттэй зарлан, батлагдсан хуваарийн дагуу www.elselt.edu.mn вебээр дамжуулан элсэлтийг зохион байгуулна.

Хүснэгт 3.

д/д	Сургалтын				
	Хэлбэр	Төрөл	Хугацаа улиралд /7 хоног/	Ерөнхий зохион байгуулалт	Хуанлийн хугацаа
1	Танхимын	Эчнээ	8	Сургалтын хугацаанд хичээлийн агуулгын 60 хувийг 6 долоо хоногийн хугацаанд танхимд, 2 долоо хоногт оюутан бие даан суралцах	Намрын улиралд IX-XVI долоо хоног, Хаврын улиралд I-VIII долоо хоног
		Гарагийн	16	Хичээлийн 16 долоо хоногийн бүрэн агуулгыг тодорхой гарагуудад суралцах	Намрын улиралд I-XVI долоо хоног, Хаврын улиралд I-XVI долоо хоног;
2	Танхимын бус	Ганцаарчилсан	16	Хичээлийн бүрэн агуулгыг суралцах	I-XVI долоо хоног;
3	Хосолсон сургалт	Цахим-танхим хосолсон	12	Хичээлийн 16 долоо хоногийн бүрэн агуулгыг 12 долоо хоногийн хугацаанд 8 (4) долоо хоног цахим, 4 (8) долоо хоног танхимаар суралцах	Намрын улиралд V-XVI долоо хоног, Хаврын улиралд I-XII долоо хоног
		Ганцаарчилсан			
		Гарагийн	16	Тодорхой гарагуудад хичээлийн бүрэн агуулгыг судлах	Намрын улиралд I-XVI долоо хоног, Хаврын улиралд I-XVI долоо хоног;



- 11.3. Танхимын сургалтын (эчнээ) хувьд 6 долоо хоногийн хугацаанд танхимд уртасгасан цагаар, үлдсэн 2 долоо хоногийн хугацаанд оюутан бие даан суралцах байдлаар сургалтыг төлөвлөж явуулна.
- 11.4. Танхимын бус (ганцаарчилсан), хосолсон (ганцаарчилсан) сургалтыг онцлог хэрэгцээ шаардсан(хөгжлийн бэрхшээлтэй), ганцаарчилсан хэлбэрээр суралцах зайлшгүй шаардлага үүссэн(эрх чөлөө нь хязгаарлагдсан, эрүүл мэндийн шалтгаантай, гадаадад түр хугацаагаар оршин суугаа), элсэлтийн журмын шаардлага хангаж элссэн оюутны хүсэлтээр хөтөлбөр хариуцсан тэнхим, сургуулийн сургалт хариуцсан нэгжийн зөвшөөрлөөр зохион байгуулна.
- 11.5. Хосолсон сургалтын хувьд 12 долоо хоногийн сургалтын харьцааг сургууль, хөтөлбөрөөс хамаарч ялгаатай байдлаар төлөвлөж, цахим хичээлийг холимог цахим(бодит хугацаа, бодит бус хугацааны) хэлбэрээр зохион байгуулах ба сургалтын материалыг LMS, Microsoft Teams, Moodle платформд урьдчилан байршуулна.
